

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР
ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА
/2023 оны жилийн эцсийн байдлаар/

2024.01.30Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Ашигт малтмал, газрын тосны газарт 2023 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”, Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 12 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу үнэлж, дүгнэх шалгуурыг үндэс болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4.4-д заасны дагуу Төрийн захиргааны удирдлагын газрын нэгтгэн ирүүлсэн тайланд үндэслэн гүйцэтгэв.

Төслийн зорилтыг хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах үр дүнг үнэлгээ хийх үед хүрсэн бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Ашигт малтмал, газрын тосны газарт 2023 онд буцалтгүй тусламжаар 2 төсөл хэрэгжсэн. БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах эрчим хүчний нөөцийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх” төслийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилсэн байна. Харин Эрдэс баялгийн салбар дахь институтийн болон боловсон хүчний чадавхыг хөгжүүлэх II БГР төсөл УУХҮЯ-д үйл ажиллагаагаа тайлагнадаг байна.

Дээрх төслийн хэрэгжилтийн тайланг Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 12 дугаар тушаалаар батлагдсан журмын 5 дугаар хүснэгтийн дагуу гарган хавсаргасан болно.

Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг доорх хүснэгтээр харуулав.

Д/д	Хөтөлбөр, төслийн нэр	Зорилтын тоо	Үнэлгээ						Хэрэг жилт
			100%	90%	70%	50%	30%	0%	

1	БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах эрчим хүчний нөөцийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх” төсөл	3	1	1	1	-	-	-	87
Нийт дүн			3	-	-	-	-	-	87%

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газарт 2023 онд 2 хөтөлбөр, төсөл хэрэгжсэнээс БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах эрчим хүчний нөөцийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх” төслийн үйл ажиллагаа жилийн эцсийн байдлаар 87 хувьтай хэрэгжсэн байна.

Төслөөр тус 2023 онд 1487.9 мянган ам.долларыг зарцуулсан бөгөөд төслийн тайлант хугацаанд Уул уурхай, газрын тосны төв лабораторийн барилгын шинэчлэл засварын ажил хийгдэж байгаа бөгөөд, газрын тосны бүтээгдэхүүн, нүүрсний хяналт шалгалт, шинжилгээний ажилтнуудад зориулсан сургалтууд, шатахуун түгээх станцуудын нөхцөл байдлын судалгааны ажлууд хийгдсэн байна.

Дөрөв. Дүгнэлт

Ашигт малтмал, газрын тосны газарт 2023 онд хэрэгжсэн төслийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар дунджаар **87.0** хувьтай үнэлэгдэв.

Тав. Зөвлөмж

1. Төслийн хэлэлцээрийн дагуу талууд хариуцсан чиг үүргийн дагуу ажиллах, төслийн зохицуулах зөвлөлийг байгуулах, Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан арга хэмжээнүүдийн гүйцэтгэлд анхаарах шаардлагатай байна.
2. Төсөл дуусах гэж байгаатай холбогдуулан батлагдсан төлөвлөгөөний биелэлтэд анхаарч ажиллах шаардлага байна.

Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт

(2023 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга		Гүйцэтгэл		
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар		“МУ-ЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЭРЧИМ ХҮЧНИЙ НӨӨЦИЙН ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ		
2	Төсөл, хөтөлбөрийн зорилго		Монгол Улсын агаарын чанарыг бууруулагч хүчин зүйлийн нэг болох автомашины бензин, түлш болон нүүрсний чанарын хяналт тогтолцоог сайжруулж чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын агаарын чанарыг сайжруулахад хувь нэмрээ оруулах		
3	Санхүүжилтийн эх үүсвэр		Буцалтгүй тусламж		
4	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		Ашигт малтмал, газрын тосны газар 5 жил		
5	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		1. Эрчим хүчний эх үүсвэрийн(газрын тосны бүтээгдэхүүн, нүүрс) чанарын хяналтын чадавхыг бэхжүүлэх 2. АМГТГ-ын Уул уурхай газрын тосны төв лабораторийн орчныг сайжруулах		
6	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	4.5 сая		
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
		Багц №	2023 он	2.180.000 USD	48.40%
7	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.		
	1-р зорилтын хүрээнд:		1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл:		
	Хүрэх үр дүн 1:		Ашигт малтмал газрын тосны газар БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах хүрээнд эрчим хүчний эх үүсвэрийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх” төслийг 2021-2025 онд хэрэгжүүлж байна. Уг төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрт Монгол Улсын Сангийн яам, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны агентлаг /KOICA/ байгууллагууд 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдөр гарын үсэг зурсан. Төслийн хүрээнд Уул уурхай, газрын тосны төв лабораторийг шинэчлэн тохижуулах, шинжилгээний тоног төхөөрөмжийг сайжруулах, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, эрчим хүчний эх үүсвэрийн стандартыг сайжруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлууд хийгдэнэ. Төслийн ерөнхий хэрэгжүүлэгчээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Газрын тосны чанар, хангамжийн газар (K-PETRO), туслан гүйцэтгэгчээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Уул уурхайн нөхөн сэргээлт, ашигт малтмалын корпорац (KOMIR) байгууллагууд ажиллаж байна. Энэ хүрээнд Ашигт малтмал газрын тосны газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Газрын тосны чанар хангамжийн газартай 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр		

	хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Зорилт 1-ийн хүрээнд: Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2023 онд дараах 4 удаагийн чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнд: Бодлогын түвшний албан тушаалтны Бүгд Найрамдах Солонгос Улс дахь сургалт. Газрын тосны бүтээгдэхүүний хяналт шалгалтын чадавхыг бэхжүүлэх. Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний чадавхыг бэхжүүлэх. Нүүрсний бүтээгдэхүүний хяналт, шалгалт, шинжилгээний чадавхыг бэхжүүлэх. 2 сургалтыг дараах байдлаар зохион байгуулсан. Үүнд: 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс 04 дүгээр сарын 21-ний өдрүүдэд төслийн хэрэгжүүлэгч БНСУ-ын Газрын тосны газар /К-Петро/-аас газрын тосны бүтээгдэхүүний чанарт тавигдах стандарт шаардлага, хяналтын тогтолцоо, хууль эрх зүйн орчин, бүтээгдэхүүнд шинжилгээ хийх арга технологийн талаарх сургалтыг зохион байгуулж Ашигт малтмал газрын тосны газар, Гаалийн Ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын Дорнод аймгийн харьяа лаборатори, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр, Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын холбогдох албан хаагчид хамрагдлаа. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан ээлжит сургалт болох Газрын тосны чанар, түгээлтийн тогтолцооны талаарх сургалтыг 2023.06.26-2023.06.29-ний өдрүүдэд БНСУ-ын К-Петро байгууллагаас 2 мэргэжилтэн сургагч багшаар ирж зохион байгуулсан. Сургалтад АМГТГ-ын УУГТТЛ-ийн болон ГТБХ-ийн мэргэжилтнүүд хамрагдсан. 2023.06.25-2023.07.01-ний өдрүүдэд БНСУ-ын К-Петро байгууллагаас Бизнесийн газрын дарга Kang Hee Du, ОУ-ын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Im Young kwan, Шалгалт хариуцсан мэргэжилтэн-лектор Kim Pan kyu, ODA Төсөл хариуцсан ажилтан Choi You Jin нар Монгол Улсад ирж төслийн үйл явцтай танилцсан. 2023.06.29-ний өдөр төслийн явцын уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад АМГТГ-ын албан хаагчид, К-Петро гийн албан хаагчид, КОЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дэд дарга, КОМИР-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал нар оролцсон. Уулзалтаар төслийн хүрээнд хийгдсэн ажлыг болон цаашид хийгдэх ажлыг танилцуулсан. К-Петро гийн зүгээс АМГТГ-ын УУГТТЛ-д шатахууны хүхрийн агууламжийг тодорхойлох багаж /Trace Sulfur Analyser/ (MITSUBISHI TS-100V) хандивласан.
2-р зорилтын хүрээнд:	2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл:
Хүрэх үр дүн 1:	Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2 дугаар зорилтын хүрээнд АМГТГ-ын УУГТТЛ-ийн барилгын их засварын зураг төслийг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг амжилттай зохион байгуулж засвар шинэчлэлийн ажлыг 50 хувийн гүйцэтгэлтэй хийж байна. Тоног төхөөрөмжийн

		хувьд БНСУ-д тендерийн сонгон шалгаруулалт явагдаж байна. УУГТТЛ-ийн барилгын засвар шинэчлэлийн ажил хийгдэхтэй холбоотойгоор лабораторийн тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх байрны түрээсийн гэрээ хийгдсэн.				
	3-р зорилтын хүрээнд:	3-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл:				
	Хүрэх үр дүн 1:	2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс К-Петро байгууллагаас төслийн удирдагч Шин Ги Ху болон төслийн мэргэжилтэн нар 2 жилийн хугацаатай Монгол Улсад томилогдон ирж ажиллаж байна. Хяналт шалгалт хариуцсан 1 солонгос мэргэжилтэн нутаг буцаж, 2023 оны 09 сарын 01-ний өдрөөс ГТБ-ний шинжилгээ хариуцсан мэргэжилтэн томилогдон ирж ажиллаж байна. Газрын тосны бүтээгдэхүүний шалгалт шинжилгээний гарын авлага болон дүрэм боловсруулах ажлын хүрээнд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм болон хууль эрх зүйг судалж, БНСУ-ын дүрэм журамтай харьцуулан боловсруулалт хийсэн. Үүний үндсэн дээр гарын авлага болон дүрмийн гарчгийг гарган суурь материал бэлтгэж эхэлсэн.				
8	Дүгнэлт	Төслийн хэлэлцээрийн дагуу талууд хариуцсан чиг үүргийн дагуу ажиллах, төслийн зохицуулах зөвлөлийг байгуулах, Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан арга хэмжээнүүдийн гүйцэтгэлд анхаарах.				
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлтийн дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		87%	100%	90%	70%	